



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23. № 3/359
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БСШУСЯ-ны харъяа "Монгол тэмүүлэл" лаборатори сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

БСШУСЯ-ны харъяа "Монгол тэмүүлэл" лаборатори сургуулийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

БСШУСЯ-ны харъяа "Монгол тэмүүлэл" лаборатори сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2017\0224SAG39.Docx

УХА0122

020473



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ ЛАБОРАТОРИ СУРГУУЛИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахи хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6
Web: www.mnao.gov.mn

Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Бэст фортуна Аудит” ХХК
Утас: 324338
И-мэйл: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465
И-мэйл: Oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Д.Наранчимэг
Утас: 98006465
И-мэйл: dnaran@yahoo.com

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

Агуулга

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	1
Байгууллагын хууль эрх зүйн орчин	2
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	2
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн	3
Материаллаг байдал	4
Дотоод хяналт	4
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	4
Шилэн дансны мэдээлэл	5
Олж тогтоосон гол эрсдлүүд	5
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	6
Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	6-7
Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	7
Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
Дүгнэлт	8

Оршил

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.1, 18.5 дахь заалтуудыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Бэст фортунa аудит” ХХК гэрээгээр аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь “Бэст фортунa Аудит” ХХК-ийн үүрэг юм.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн завсрын аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 22-наас 2016 оны 10 дугаар сарын 01-ны хооронд, жилийн эцсийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 17-наас 2017 оны 02 дугаар сарын 14-ны хооронд хийхээр төлөвлөн “Бэст фортунa Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 23-нд “Бэст фортуна Аудит” ХХК нь тус сургууль дээр очиж эхлүүлсэн ба өөрийн ажлын байранд баримтыг авч үргэлжлүүлэн гүйцэтгэсэн болно.

“Бэст фортуна Аудит” ХХК нь завсрын аудитын гүйцэтгэлийг 2016 оны 12 дугаар сарын 01-нд танилцуулж, зөвлөмжийг хүлээлгэн өгсөн ба Шинэ эхлэл лаборатори сургууль 2016 оны жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 01 дүгээр сарын 25-нд 02/01–р албан бичгээр ирүүлсэн байна.

“Бэст фортуна Аудит” ХХК-ийн аудитын баг аудитын дуусгавар болсон тайлан, менежментийн захидлыг 2017 оны 2 дугаар сарын 16-нд Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн удирдлагад танилцуулсан.

2. Байгууллагын хууль эрх зүйн орчин:

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн удирдлага нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлангийн хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн зорилго нь Чанартай боловсролыг эзэмшүүлж дэлхийн иргэнийг бэлтгэнэ.

БШУЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай Монгол тэмүүлэл лаборатори сургууль нь Монгол улсын болон Кембриджийн хөтөлбөрөөр хос хэлээр хичээллэдэг ба сургалтын үйл ажиллагааг сурагчдын эрэлт хэрэгцээ, сургуулийн онцлогт тулгуурлан уян хатан байдлаар төлөвлөн зохион байгуулдгаараа онцлог юм. Манай үндэсний болон Кембриджийн IGCSE, AS/A түвшний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн зэрэгцээ сурагч бүрийн авьяас сонирхлыг хөгжүүлэх зорилгоор хичээлээс гадуурх үйл ажиллагааг олон хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Олон улсын шалгалтын төвөөр дамжуулан хичээлүүдийн шалгалтыг жилд 2 удаа /5,11 сард/ зохион байгуулдаг ба бүх шалгалт англи хэл дээр явагддаг.

Кембрижийн олон улсын дунд боловсролын хөтөлбөр нь олон улсын жишигт нийцсэн хөтөлбөр бөгөөд үндсэн 4 үе шаттай.

Cambridge Checkpoint-г сонгосон IGCSE түвшинд дэвшин суралцахад шаардагдах суурь мэдлэг чадварыг олгодог. Энэ хөтөлбөрөөр англи хэл, математик, байгалийн шинжлэх ухааны хичээлүүдийг судалдаг.

Кембрижийн дунд боловсрол-2 /IGCSE / Олон улсын дунд боловсролын Сертификат 14-16 насны суралцагчид сонгон судалдаг олон улсад түгээмэл хөтөлбөр юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр

ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагийн дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн захирал Төсвийн захирагчийн үүрэг гүйцэтгэж байна. Сургуулийн 2016 оны төсвийг Төрийн сангаас олгож байна. Төсвийн захирагчтай шууд холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хуулиудыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд дээрхи хууль, бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашигласан болно.

Аудитаар Шинэ эхлэл лаборатори сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн шууд захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, материаллаг дүнтэй зарим гүйлгээнүүдийг түүвэрчилсэн байдлаар аудитын 18 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас батлагдсан нэгдсэн загварыг үндэслэн өөрийн онцлогт тохируулан боловсруулж мөрдсөн байна.

Шинэ эхлэл лаборатори сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, программд нэвтрэх зэрэг аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн болно. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, боловсруулах үйл ажиллагааг "ACOULOS" санхүүгийн программыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 27 эрсдэлтэй асуудалд 12 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав./ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 16.6 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

5. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн төсвийн зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн төсвийн зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсвийн санхүүжилтыг зориулалтын бусаар зарцуулах, хэтрүүлсэн зардлыг хэмнэсэн бусад зардлаар тайлагнах шийдвэргүйгээр зардал гарах зэрэг эрсдэл гардагтай холбоотой юм.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тооцохдоо 2016 оны батлагдсан төсвийн эхний 6 сарын зардлаар суурь үзүүлэлт болгон сонгож 1 хувиар буюу 3,499.4 мянган төгрөгөөр тооцсон ба 2016 оны нийт зардал 633,757.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь 6,337.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь нийт санхүүжилтын хувьд бага, бага дүнтэй олон гүйлгээтэй холбоотой юм.

6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн дотоод хяналтын эрсдлийн 2 эрсдэл үр нөлөөтэй, 22 эрсдэл үр нөлөөгүй гэж тооцсон. /ТАБ-СТА-А-4-өөс үзнэ үү/

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу төв төрийн сан тус байгууллагын дансаар олгож, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан зарцуулалтанд хяналт тавьж ажилласан байна.

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн үйл ажиллагааны төсөв 2016 онд 575,824.7 мянган төгрөгөөр батлагдснаас 575,825.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 7,406.3 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 5,500.0 мянган

төгрөгийг нэмэлт санхүүжилтаар, 10,980.6 мянган төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны орлогоор олсон ба төсвийн хөрөнгийг ангилалын дагуу зохистой зарцуулсан байна. Харин шуудан холбоо, интернэтийн төлбөр 1,007.7 мянган төгрөгөөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн зүйлс 1,820.9 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн нь дээрх зардлуудыг бодитоор төлөвлөсөн боловч төлөвлөгөө батлахад хассанаас болсон гэж үйлчлүүлэгчийн зүгээс тайлбарлав.

Дансны өглөгийн оны эцсийн үлдэгдэл 894.3 мянган төгрөг нь НДШ-ийн өглөг байна.

Тайланд тусгасан бараа материал, үндсэн хөрөнгө нь бодитойгоор оршин байгаа ба байгууллагын өмчлөлд байгаа бүхий л өмч хөрөнгийг бүрэн хамруулж, орлого, зарлага болон шилжилт хөдөлгөөн, бусад зарлагын гүйлгээнүүд нь данс, дүн, хугацаа, ангиллын хувьд үнэн зөв бүртгэгдсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Монгол тэмүүлэл лаборатори сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 1 горим сорил хэрэгжүүлэв.

Байгууллагын цахим хуудсанд байгууллагын мэдээлэлүүд, 2016 оны төсвийн гүйцэтгэлийг оруулсан байна. Байгууллагын самбараар дамжуулан төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг нээлттэй хүргэж байна.

9. Олж тогтоосон гол эрсдлүүд

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 22 эрсдэлтэй асуудал тодорхойлон, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 горим, сорил гүйцэтгэж доорхи эрсдлүүдийг олж тогтоон тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягад нэгтгэж, баримтжуулав.

Үүнд:

Материал буруу ангилагдан бүртгэгдсэн байх Э-2

Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого, тооцоог цаг хугацаанд нь хийгээгүй байх Э-3

Үндсэн хөрөнгө, зардал буруу ангилагдан бүртгэгдсэн байх Э-8

Баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрсөн байх Э-10

Авлага, өглөг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгагдсан байх Э-1

Санхүүгийн тайлангийн судалгаа шинжилгээ хийдэггүй байх Э-24

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 4 асуудал эрсдэл дунд, 18 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 18.2 % байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 4 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг асуулга, тулган баталгаажуулах, түүвэрлэн шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Анхаарал татахуйц гол, онцлог тохиромжтой гүйлгээ байхгүй

11. Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтуудад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад доорхи материаллаг хэмжээтэй алдаа зөрчилүүд нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсан ба холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан дахь НДШ-ийн өглөг дансны үлдэгдэл 1,164.2 мянган төгрөг, НДШ-ийн тайлангийн авлагын үлдэгдэл 3,601.9 мянган төгрөг байгаа ба НД-ын тайланд тооцсон цалинг 22,347.7 мянган төгрөгөөр дутуу, 4,693.2 мянган төгрөгийн өр тайлагнаагүй тул дээрх авлага, өглөгийн дансны үлдэгдэл 2016 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар зөрүүтэй гарсан нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 хэсэг дэх “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”** гэсэн заалттай нийцэхгүй байна

✓ **Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгсөн, зөрүүг 7-р сарын тайланд нэмж тайлагнан арилгасан

2. Цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан дахь цалин хөлсний дүнг 2-р улирлын байдлаар 132.4 мян.төгрөг, ХХОАТ-ын дүнг 89.9 мян.төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 хэсэг дэх “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”** гэсэн заалттай нийцэхгүй байна

✓ **Шийдвэрлэсэн нь:** Тайланг залруулах, хойшид зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгсөн

3. Бараа материалын зарим зардал үндсэн баримтгүй, мөнгөн хөрөнгийн кассын баримтанд хүлээн авсан хүний гарын үсэггүй (5-сарын 5-ны 404,4 мян.төгрөг гэх мэт) нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 хэсэг дэх “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”** гэсэн заалттай нийцэхгүй байна
гэсэн заалтуудтай нийцэхгүй байна

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Хойшид иж бүрдэлтэй, хүчин төгөлдөр баримтаар гүйлгээ хийж байх, гарын үсгийг нөхөн зуруулах, дутагдлыг давтахгүй байх зөвлөмж өгсөн

4. Тайлангийн эхний хагас жилийн бараа материалын тооллого хийгээгүй, жилийн эцсийн тооллогын үр дүнгээр тооцоо бодоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь **“Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 хэсэг дэх “Эд хөрөнгийн тооллогыг дараахь тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 хэсэг дэх “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6 хэсэг дэх “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”** гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Бараа материалын тооллогыг жилд 2 удаа, Үндсэн хөрөнгийн тооллогыг жилд 1 удаа хийж, тооцоо бодож үр дүнг удирдлагад танилцуулж байх зөвлөмж өгсөн

5. Бараа материалын дансанд бүртгэх зарим зүйлсийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн (вирусны програм, модон шугам, уян душ, штатив, хуруун шилний тавиур гэх мэт)

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Үндсэн хөрөнгө, бараа материалын дансдад бүртгэгдэх хөрөнгө материалыг зөв ангилах, залруулан бүртгэх зөвлөмж өгсөн

Аудитаар илэрсэн бусад асуудлуудыг Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн удирдлага авч үзэж, өгсөн зөвлөмжийг хойшид ажилдаа мөрдөж ажиллахаар болсон тул материаллаг алдаагүй гэж үзлээ.

12.Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Бараа материалын дансанд бүртгэх зарим зүйлсийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн (вирусны програм, модон шугам, уян душ, штатив, хуруун шилний тавиур гэх мэт) алдаа залруулагдаагүй болно.

13.Анхаарал татахуйц бусад чухал асуудал

БСШУ-ны яамны сайдын 2016 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 1/5642 тоот тушаалаар 2015 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд Үндэсний аудитын газраас “Зөрчилгүй санал дүгнэлт” ирүүлсэнтэй холбогдуулан байгууллагын нягтлан бодогч нарт байгууллагын төсөвтөө багтаан 1 ба түүнээс дээш сарын цалингаар балансын урамшуулал олгох санал ирүүлсэн ба үүний дагуу Сургуулийн захирал тушаал гаргаж нягтлан бодогчид 3 сарын цалинтай тэнцэх урамшуулал олгосон байх тул төсөв хүндрэлтэй байгаа хугацаанд урамшуулалын дээд хэмжээг хязгаарлах талаар сайдад албан шаардлага хүргүүлэх саналтай байна

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад үзэж амжаагүй асуудал байхгүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 404.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба аудитын явцад зөрчлийг арилгасан болно.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх болон “Бэст фортуна аудит” ХХК-аас завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна

17. Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгуудад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэн “**Зөрчилгүй**” санал дүгнэлт гаргалаа.



МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ ЛАБОРАТОРИ СУРГУУЛИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахи хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6

Web: www.mnao.gov.mn

Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Бэст фортуна Аудит” ХХК
Утас: 324338
И-мэйл: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465
И-мэйл: Oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Д.Наранчимэг
Утас: 98006465
И-мэйл: dnaran@yahoo.com

Тэргүүлэх ач холбогдол №2

Асуудал 1: Санхүүгийн тайлагнал,
зардлын ангилал

Асуудал 2: Үндсэн хөрөнгө, бараа
материалын тооллого, тооцоо
бодолт, ангилал

Асуудал 3: Мөнгөн хөрөнгө

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Монгол тэмүүлэл лаборатори сургуулийн удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим сорил нь санхүүгийн тайлан, илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Энэхүү зөвлөмж танай байгууллагын бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан удирдлага болон бусад ажилтануудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Санхүүгийн тайлагнал,
зардлын ангилал**

Тэргүүлэх ач холбогдол № 2

Аудитын ажиглалт

1. Санхүүгийн тайлан дахь НДШ-ийн өглөг дансны үлдэгдэл 1,164.2 мянган төгрөг, НДШ-ийн тайлангийн авлагын үлдэгдэл 3,601.9 мянган төгрөг байгаа ба НД-ын тайланд тооцсон цалинг 22,347.7 мянган төгрөгөөр дутуу, 4,693.2 мянган төгрөгийн өр тайлагнаагүй тул дээрх авлага, өглөгийн дансны үлдэгдэл 2016 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар зөрүүтэй гарсан

2. Цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан дахь цалин хөлсний дүнг 2-р улирлын байдлаар 132.4 мян.төгрөг, ХХОАТ-ын дүнг 89.9 мян.төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 хэсэг дэх “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтад нийцэхгүй байна**

Эрсдэл

Санхүүгийн тайлангийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх,

(О, Т, Ү)

Аудитын зөвлөмж

1. НДХ-тэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах

2. ХХОАТ-ын тайлангийн зөрүүг нэмж тайлагнах

Үйлчлүүлэгчийн хариу

1. Үлдэгдлийг баталгаажуулж зөрүүг 7-р сарын тайланд нэмж тайлагнасан ба хойшид зөрчлийг дахин давтахгүй

2. ХХОАТ-ын зөрүүг 3-р улирлын тайланд нэмж тайлагнасан

Аудитын ажиглалт

1. Тайлангийн эхний хагас жилийн бараа материалын тооллого хийгээгүй, жилийн эцсийн тооллогын үр дүнгээр тооцоо бодоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 хэсэг дэх “Эд хөрөнгийн тооллогыг дараахь тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 хэсэг дэх “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6 хэсэг дэх “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудад нийцэхгүй байна

2. Бараа материалын дансанд бүртгэх зарим зүйлсийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн (вирусны програм, модон шугам, уян душ, штатив, хуруун шилний тавиур гэх мэт) нь НББОУС-ын үндсэн хөрөнгө, бараа материалын зүйлсийн тодорхойлолтод нийцэхгүй байна.

Эрсдэл

Хөрөнгийн ашиглалтын байдал, хөрөнгө биет байдлаар оршин байгаа эсэх нь тодорхойгүй болох, илүүдэл, дутагдал тодорхойлогдохгүй болох, элэгдлийн байдлаас шалтгаалан зардал, улмаар санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх
(О, Т, Y)

Аудитын зөвлөмж

1. Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай хийж гүйцэтгэн нягтлан бодогч тооцоог бодож үр дүнг удирдлагад танилцуулж хэвших
2. Үндсэн хөрөнгө, бараа материалын шинж чанар, эдэлгээний хугацаа, үнийг харгалзан зөв ангилан нягтлан бодох бүртгэлд тусгаж байх

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ

Асуудал 3: Мөнгөн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол № 2

Аудитын ажиглалт

Хангамжийн болон бичиг хэргийн зардал үндсэн баримтгүй, мөнгө хүлээн авсан хүний гарын үсэггүй (5-сарын 5-ны 404,4 мян.төгрөггэхмэт) нь **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 хэсэг дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”** гэсэн заалттай нийцэхгүй байна

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулах, хөрөнгийн ашиглал буй болох

(О, Т, Ү)

Аудитын зөвлөмж

Хойшид иж бүрдэлтэй, хүчин төгөлдөр баримтаар гүйлгээ хийж байх, гарын үсгийг нөхөн зуруулах, дутагдлыг давтахгүй байх зөвлөмж өгсөн

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын явцад зөрчлийг арилгасан, хойшид зөрчлийг дахин давтахгүй

**МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,936,286.00	1,055,831.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	2,073.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		2,073.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,936,286.00	1,053,758.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,350,028.00	181,500.00
354	Хангамжийн материал	1,586,258.00	872,258.00
35460	Хүнсний материал	1,586,258.00	872,258.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	823,541,935.00	811,703,137.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	823,541,935.00	811,703,137.46
391	Газар		
392	Биет хөрөнгө	822,857,735.00	811,087,357.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,878,873.00	13,878,873.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,775,774.00)	(4,163,661.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,502,610.73	43,727,018.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,389,818.73)	(22,676,274.97)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	776,169,020.00	776,169,020.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,718,984.00	18,718,984.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,246,160.00)	(16,076,601.90)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		1,510,000.00
393	Биет бус хөрөнгө	684,200.00	615,779.96
39301	Програм хангамж	684,200.00	684,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(68,420.04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	828,478,221.00	812,758,968.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	110,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	110,000.00	-
413	Өглөг	110,000.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	110,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	828,368,221.00	812,758,968.46
51	Засгийн газрын хувь оролцоо	828,368,221.00	812,758,968.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	70,433,859.73	70,433,859.73
51101	Өмч: - төрийн	70,433,859.73	70,433,859.73
512	Хуримтлагдсан үр дүн	37,214,428.27	21,605,175.73
51210	Өмнөх үеийн үр дүн	37,214,428.27	37,214,428.27
51220	Тайлант үеийн үр дүн		(15,609,252.54)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	720,719,933.00	720,719,933.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	828,478,221.00	812,758,968.46

**МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	138,542,579.22	138,056,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,266,500.00	3,791,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,266,500.00	3,791,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,266,500.00	3,791,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,266,500.00	2,049,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		231,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,510,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	136,276,079.22	134,265,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	135,632,500.00	134,265,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	135,632,500.00	134,265,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	643,579.22	-
131106	Төсвийн урамшуулал	643,579.22	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	147,120,617.22	152,289,668.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	147,120,617.22	152,289,668.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	142,453,030.60	152,001,052.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,474,298.00	97,200,099.73
210101	Үндсэн цалин	94,474,298.00	97,200,099.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,578,784.00	10,726,487.00
210201	Тэтгэврийн даатгал	6,810,459.00	6,558,179.00
210202	Тэтгэмжийн даатгал	766,307.00	766,307.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	946,702.00	486,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	189,008.00	972,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,866,308.00	1,944,001.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,930,000.00	21,190,500.00
210304	Байрны түрээс	24,930,000.00	21,190,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	637,381.60	5,554,952.10
210401	Бичиг хэрэг		133,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	637,381.60	1,005,632.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,416,320.00
2105	Нормативт зардал	33,000.00	249,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,000.00	249,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	102,800.00
210604	Урсгал засвар		102,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	88,000.00
210702	Дотоод албан томилолт		88,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	2,983,329.00	4,684,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,983,329.00	4,184,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,816,238.00	12,204,513.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	220,272.00	231,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,595,966.00	11,972,713.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,667,586.62	288,616.17
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,667,586.62	288,616.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,667,586.62	288,616.17

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(8,578,038.00)</u>	<u>(14,233,168.34)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,376,084.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		1,376,084.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,376,084.20)
5	НИЙТ ҮР ДҮН	<u>(8,578,038.00)</u>	<u>(15,609,252.54)</u>

**МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	138,542,129.22	136,546,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,910,079.22	2,281,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,910,079.22	2,281,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,910,079.22	2,281,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,266,500.00	2,049,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		231,800.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	643,579.22	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,632,050.00	134,265,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	135,632,050.00	134,265,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	135,632,050.00	134,265,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	138,542,129.22	136,546,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,542,129.22	136,546,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,874,542.60	136,257,883.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,474,298.00	97,312,172.73
210101	Үндсэн цалин	86,655,498.00	87,850,246.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,551,600.00	4,961,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,267,200.00	4,500,726.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,578,784.00	10,726,487.00
210201	Тэтгэврийн даатгал	6,810,459.00	6,558,179.00
210202	Тэтгэмжийн даатгал	766,307.00	766,307.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	946,702.00	486,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	189,008.00	972,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,866,308.00	1,944,001.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,930,000.00	21,190,500.00
210304	Байрны түрээс	24,930,000.00	21,190,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	693,381.60	1,672,424.10
210401	Бичиг хэрэг	56,000.00	133,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	637,381.60	1,005,632.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		533,792.00
2105	Нормативт зардал	33,000.00	249,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,000.00	249,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	593,074.00	102,800.00
210602	Тавилга	400,000.00	
210604	Урсгал засвар	193,074.00	102,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	88,000.00
210702	Дотоод албан томилолт		88,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,572,005.00	4,684,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,572,005.00	4,184,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	231,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		231,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,667,586.62	288,616.17
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,667,586.62	288,616.17
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,667,586.62	

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		288,616.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

**МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	37,214,428.27		828,368,221.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	37,214,428.27	-	828,368,221.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	37,214,428.27	-	828,368,221.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	37,214,428.27	-	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	37,214,428.27	-	828,368,221.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(15,609,252.54)		(15,609,252.54)
D09	6 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,433,859.73	720,719,933.00	21,605,175.73	-	812,758,968.46

**МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	136,423,200.00	136,026,083.83	397,116.17	99.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	136,423,200.00	136,026,083.83	397,116.17	99.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,423,200.00	136,026,083.83	397,116.17	99.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,519,500.00	97,312,172.73	207,327.27	99.79
210101	Үндсэн цалин	87,458,100.00	87,850,246.73	(392,146.73)	100.45
210102	Нэмэгдэл				
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,419,300.00	4,961,200.00	458,100.00	91.55
210104	Урамшуулал	4,642,100.00	4,500,726.00	141,374.00	96.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,727,200.00	10,726,487.00	713.00	99.99
210201	Тэтгэврийн даатгал	6,810,459.00	6,558,179.00		
210202	Тэтгэмжийн даатгал	766,307.00	766,307.00		
210203	ҮОМШӨ-ний даатгал	946,702.00	486,000.00		
210204	Ажилгүйдлийн даатгал	189,008.00	972,000.00		
210205	Эрүүл мэндийн даатгал	2,014,724.00	1,944,001.00		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,190,500.00	21,190,500.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,672,800.00	1,672,424.10	375.90	99.98
210401	Бичиг хэрэг	133,100.00	133,000.00	100.00	99.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,005,700.00	1,005,632.10	67.90	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	534,000.00	533,792.00	208.00	99.96
2105	Нормативт зардал	250,000.00	249,500.00	500.00	99.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00	249,500.00	500.00	99.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	246,600.00	102,800.00	143,800.00	41.69
210604	Урсгал засвар	246,600.00	102,800.00	143,800.00	41.69
2107	Томиллолт, зочны зардал	131,700.00	88,000.00	43,700.00	66.82
210702	Дотоод албан томилолт	131,700.00	88,000.00	43,700.00	66.82
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа	4,684,900.00	4,684,200.00	700.00	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний т	4,184,900.00	4,184,200.00	700.00	99.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00		100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	136,663,000.00	2,049,500.00		
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	134,505,000.00	-		
131001	Улсын төсвөөс санхүүжих	134,505,000.00			
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,158,000.00	2,049,500.00	108,500.00	94.97
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,158,000.00	2,049,500.00	108,500.00	94.97
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-		
610001	Төсвийн байгууллага				
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	-		
620001	Удирдах ажилтан	1.00			
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00			
620003	Үйлчлэх ажилтан	4.00			
620004	Гэрээт ажилтан	1.00			

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11.00	11.00		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	5.00	5.00		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00		
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00		